

субъект-хилийн цэрэг маань төрийн аль нэг яам, газрын хажуу бөөрөнд хавчуулагдаж улсын хилийн талаар бие даасан бодлого явуулах нь бүү хэл төсөв хөрөнгөө захиран зарцуулах хүртэлх наад захын эрх дархаа эдэлж чадахгүйд хүрч хил хамгаалалтын хүч хэрэгслийн өсөлт, хөгжилт энэ хэмжээгээр саарч, буурч байна.

Тийм учраас "Улсын хил хамгаалалтын талаар төрөөс баримтлах бодлогын үндэс", "Улсын хилийг хамгаалах тухай хууль" - ийг боловсруулан гаргаж, холбогдох бусад хууль тогтоомжид байгаа улсын хил, хилийн хамгаалалт, хилийн цэрэгтэй холбоотой зүйл заалт, үзэл баримтлалыг эргэж харах, өөрчлөх замаар улсын хил хамгаалалтын эрх зүйн үндсийг нийгмийн өнөөгийн захиалга, шаардлагын дагуу шинэчлэн өөрчилж, баталгаажуулах явдал мэргэжлийн байгууллагын өмнө урьд урьдаас улам хурцаар тавигдаж байна.

* * *

*ХЦДС-ийн ШНА-ны тэнхимийн эрхлэгч, дэд
профессор, дэд хурандаа Б.Ахагва.*

ХИЛИЙН ЦЭРГИЙН АР ТАЛ ХАНГАЛТЫН ТОГТОЛЦООНЫ ТОЛӨВШИЛТИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Монгол оронд тодорхой зорилго чиглэлээр үүсч байгуулагдсан улс төрийн намууд засгийн эрхийн төлөө тэмцэлдээ хилийн асуудлыг ашиглаж байгаагаас хил хамгаалалтын төв байгууллага засгийн эрх баригч хүчний бодлогоор нэг байгууллагын харьяаллаас нөгөө байгууллагад ойр ойрхон шилжсэнээс, ар тал хангалтын тогтолцоо нь зарим талаар алдагдахад хүрч байна.

Иймээс төрийн хилийн бодлогыг зөв тодорхойлж онолын үндэслэлийг оновчтой гаргаж тавих нь манай эрдэмтэд, багш нарын гол зорилт болж байна.

Манай орны эдийн засгийн өнөөгийн байдал нь хилийн цэргийг хэвийн үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг бүрэн хангаж хараахан чадахгүй байна. Үүний хажуугаар албан тушаалын хийрхэл, хүнд сурталч нэрмээс болж байна.

Хилийн цэрэг БХЯ-ны харьяалалд байсан сүүлийн дөрвөн жилд улсын төсвөөс авах санхүүжилтийн 30 орчим хувийг дутуу авсны гадна

нисэх эскадриль, ансамбль, эмнэлэг, сургууль зэрэг байгууллагуудаа тараан алдаж заримыг нь сэргээн байгуулах гэж хүч, хөрөнгө, хугацаа үрж байна.

Хүн төрөлхтний түүхэн хөгжлийн гол чиг хандлага зах зээлийн эдийн засгийн харилцаанд улс орон шилжих үйл явц үргэлжилсээр байна. Хүн төрөлхтний зүй ёсны хөгжлийн энэ замаас манай орон эргэж буцах боломж нэгэнт үгүй билээ.

Төрийн хилийн бодлого, эдийн засгийн бодлогын харилцан шүтэлцээ нь нэг нь нөгөөдөө шууд нөлөөлдөггүй бөгөөд эдийн засгийн төв байгууллагуудаар дамжин хэрэгжинэ. Эдийн засгийн төв байгууллагууд хилийн цэргийн захиалгыг үндэслэн хангах ажиллагааг зохион байгуулдаг.

Ингэхдээ тус орны эдийн засгийн нөөцийн байдал, хилийн хамгаалалтанд зайлшгүй шаардлагатай хэрэгцээ зэргийг тооцон үзэж улс орны эдийн засгийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлдэг. Энэ төлөвлөгөөнд хилийн цэргийг хэрэгцээт зүйлээр хангахтай холбогдсон урсгал зардлыг санхүүжүүлэх, нөөцийг хэрэглэгчдийн хооронд хувиарлах зэрэг асуудлыг тусгана.

Өнөө үед улс орны эдийн засгийн байдал хүндэрч санхүүгийн гүн хямралд орж өрийн сүлжээнд баригдсан байгаа нь хилийн цэрэгт хүндээр тусч байна.

Өнгөрөгч оны эцсийн байдлаар хилийн зарим хороо 9 дүгээр сараас хойш цалингаа тавиагүй, хилийн цэргийн хэмжээгээр бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудад төлөх өр бараг 3 тэрбум төгрөгт хүрсэн байна. Хилийн анги байгууллагуудын урсгал засвар, сургалтын материаллаг баазын хангалт үндсэндээ зогсож хүнсний тогтоосон нөөц бараг 70%-иар буурч хилийн цэргийн бие бүрэлдэхүүн, офицеруудын хилчин гэдэг нэр хүнд эрх зүйн хамгаалалт алдагдахад хүрч тэдгээрийн гэр бүл, цэргийн албан хаагчдын нийгэм ахуйн хангалт ихээхэн буурсан байна.

Хилийн цэргийн холбогдох байгууллагуудад явуулсан социологын судалгааны дүнгээс үзэхэд офицер ахлагч нарын 60 орчим хувь нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой ядуучуудын эгнээнд орсон тооцоо гарсан байна.

Хилийн цэргийн ар талын хангалт гэдэг нь анги хорооны байлдааны бэлтгэл сургууль, соёл хүмүүжлийн ажил, байлдааны бэлэн байдлыг хангах зорилгоор захирагч, штабаас төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлж байгаа зохион байгуулалтын цогцолбор арга хэмжээг хэлэх бөгөөд материал хэрэгслийг бэлтгэх, татан авах, хадгалалт, хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг зохион байгуулах, бие

бүрэлдэхүүний тусгай бэлтгэлийн сургалт зэргийг өөртөө багтааж байна.

Хилийн цэргийн ар талын хангалт нь дараахь хэсгүүдээс бүрдэж байна.Үүнд:

- Хүнсний
- Хувцас,тоног хэрэглэлийн
- Зэвсэг галт хэрэглэлийн
- Шатахуун тосолгооны материалын
- Барилга орон сууцны
- Техникийн
- Хүн эмнэлгийн
- Зоо мал эмнэлгийн
- Санхүүгийн хангалт гэж томъёолж болох юм.

Бид зарим үед ар талын хангалтыг материал хэрэгслийн хангалттай хутгах явдал гарсаар байна.

Материал хэрэгсэл гэдэг нь ангиудын хэрэгцээг хангахад шаардагдах бүх төрлийн зэвсэглэл,байлдааны ба тусгай зориулалтын болон бусад техник тоног төхөөрөмж,сум галт хэрэглэл,шатахуун,тосолгооны материал тусгай шингэн хүнс,хувцас,инженер,холбоо,хими, орон сууцны эд хогшил,эм уусмал,ороох боох материал,мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Хилийн цэргийн ар талын хангалтын төрлүүдийг нэгийг нь нөгөөгөөс салангид ойлгох, сөргүүлэн тавих нь ар талын хангалтын тогтолцоог алдагдуулахад хүргэдгийг анхаарах нь зүйтэй. Ар талын хангалтын төрлүүд нь өөр хоорондоо холбоотой бөгөөд нэг нь тасалдахад анги салбарын бэлэн байдал суларч хилчдийн ахуй,хангамж доройтон улмаар бие бүрэлдэхүүний санаа сэтгэл алдагдахад хүрдэг.

Улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж бүхнийг мөнгөөр хэмжин, хөдөлмөр таваар болж байгаа өнөөгийн нөхцөлд санхүүгийн хангалтын үүрэг роль өсч,хангалтын бусад төрлүүдийн эх булаг болох хандлага ажиглагдаж байна.

Чухамхүү ийм учраас ар талын хангалтыг хэрэгжүүлэгч субъектүүд нь дараахь байгууллага байх зайлшгүй шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Үүнд:

1. Монгол Улсын Ерөнхийлөгч

- хилийн цэргийн албан хаагчдын дүрэмт хувцасны загварыг батална.
- Хилчдийн ахуй хангамж нийгмийн байдлын талаар Монгол Улсын Засгийн Газарт чиглэл өгнө.

- Хилийн цэргийн анги, байгууллагыг байгуулах, татагч буулгах, байлдааны туг, төрийн одон медаль олгох асуудлыг шийдвэрлэнэ.

2. Монгол Улсын Их Хурал

- Монгол улсын төрийн хилийн бодлогыг тодорхойлох, хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийг соёрхон батлах,
- Улсын хил хамгаалалтын нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх хууль эрх зүй, нийгэм- эдийн засгийн холбоотой хууль тогтоомжийг батлан гаргана.
- Хууль тогтоомжийн биелэлтийг хянана,
- Хилийн цэргийн төсвийг хянаж батлана.

3. Монгол Улсын Засгийн Газар

- Хилийн цэргийн төсөв, төлөвлөгөөг боловсруулан, батлуулахаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх,
- Хилийн цэргийн хэрэгцээг хангахаар материал хэрэгслийн захиалга, даалгаварыг төрийн яамд, орон нутгийн засаг дарга нарт өгөх, биелэлтийг хангах,
- Хилийн цэргийн холбогдох нөөцийг бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэх.

4. Төрийн яамд

- Засгийн газрын захиалга даалгаварыг биелүүлж, Хилийн цэргийг материал хэрэгслээр хангах арга хэмжээг зохицуулах,

5. Аймаг, нийслэлийн засаг дарга

- Засгийн газрын захиалга даалгаврыг нутаг дэвсгэр дэх өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгжээр биелүүлүүлэх арга хэмжээг зохион байгуулах,
- Орон нутгаас хангагддаг хилийн анги, салбарыг тухайн материал хэрэгслээр хангах,
- Хилийн анги, салбарыг дэд бүтцэд ойртуулан, холбоход дөхөм үзүүлэх,

6. Хилийн Цэргийг Удирдах Газар

- Ар талын хангалтыг тодорхой бодлого төлөвлөгөөгөөр бие бүрэлдэхүүнд ойртуулан зохион байгуулах, хангалтын шинэ эх булаг, ашиглагдаагүй нөөцийг илрүүлэх, ар талын хангалтын нөөцийг шаардлагатай хэмжээгээр байгуулан, зөв цуваажуулан байршуулах,
- Арвилан хэмнэлтийн горим, аж ахуйн дотоод тооцоог нэвтрүүлснээр үргүй зардлыг багасгах,
- Хилийн цэргийн ар талын хангалтын журмыг тууштай

хэрэгжүүлж хангалтыг хилийн хороо хүртэл хийж, анги байгууллагын аж ахуйн бие даасан байдлыг хангах

7.Хилийн хороо

- Төлөвлөгөөт жилийн ар талын хангалтын төсөв, төлөвлөгөөг шинжлэх ухааны үндслэлтэй боловсруулснаар бодит хэрэгцээг зөв тооцоолж, шаардлагатай төсвийг улсаас цаг тухайд нь авах,
- Хэрэгцээт зүйлийг олж бэлтгэх, түүний хадгалалт, хамгаалалт, ашиглалт, эзэмшилтийг зөв зохион байгуулснаар үргүй зардлыг багасган, нөөцийг бүрдүүлэх,
- Ар талын хангалтыг "хангалтын төвд-хүн" гэсэн үндсэн зарчимд тулгуурлан цаг хугацаанд нь зөв хийснээр хилийн хамгаалалтын чанар үр өгөөжийг дээшлүүлэхэд бодит нөлөө үзүүлэх,

Улсын хил хамгаалалтын ар талын хангалтын тогтолцоо нь дор дурдсан арга замаар хэрэгжинэ.

- Төвлөрсөн,
- Орон нутгийн,
- Холимог хангалтын журмаар тус тус хэрэгжинэ.

✿**Төвлөрсөн хангалт гэдэг нь** дээд шатны байгууллага нь доод шатны байгууллагын захиалгыг үндэслэн тухайн байгууллагын жилийн төсөвт нь тохируулан мэргэжлийн албадын гаргасан хувиараар шууд хийхийг хэлнэ. Төвлөрсөн хангалтаар:

- Тухайн хорооны төсвийн санхүүжилт,
- Зэвсэг, галт хэрэглэл,
- Хил хамгаалалтын болон байлдааны зориулалттай техник,
- Цэргийн албан хаагчдын дүрэмт хувцас,
- Автомашин, тусгай зориулалтын техник хэрэгсэл,
- Орон нутагт олдоц багатай хүнсний бүтээгдэхүүн, хүн, мал эмнэлэгийн эм тариа.

✿**Орон нутгийн хангалт гэдэг нь** тухайн хилийн хороо жилийн батлагдсан төсөвдөө багтаан оршиж буй, орон нутгийн аж ахуйн нэгжүүдтэй харилцан тохиролцож, аж ахуйн гэрээ байгуулсны үндсэн дээр хийгдэж байгаа хангалтуудыг хэлнэ. Энэ хангалт одоо 90 орчим хувийг эзэлж байна. Орон нутгийн хангалтаар:

- Шатахуун тосолгооны материал, тусгай шингэн,
- Түлээ, нүүрс

- Хүнсний бүтээгдэхүүн, хүн, малын эм тариа, ороох боох материал,
- Бичгийн болон ариун цэврийн материал,

❁ **Холимог хангалт гэдэг нь** төвлөрсөн болон орон нутгийн

хангалтаар зэрэг хийгдэх хангалтуудыг хэлнэ. Холимог хангалтаар:

- Зарим нэрийн хүнсний бүтээгдэхүүн,
- Хүн, мал эмнэлгийн эм тариа, ороох боох материал,
- Зарим нэрийн барилгын материалын хангалтыг тус тус хийнэ.

Улсын хилийн хамгаалалтын ар талын хангалтын тогтолцоо нь нэгэнт бүрэлдэн бий болсон хэдий ч өнөөгийн шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байна. Энэ нь өнөөгийн нөхцөлд ар талын хангалтад мөрдөж байгаа дүрэм, заавар нь зарим талаар тохирохоо больсон, ар талын хангалт үйлчилгээг гардан гүйцэтгэгч бүрэлдэхүүний мэдлэг чадварын түвшин эдийн засгийн шинэ харилцааны шаардлагаас хоцорч байгаа зэрэгтэй холбоотой юм.

Хилийн цэргийн ар талын хангалтын тогтолцоог цаашид төлөвшүүлэн сайжруулахад дараахь зүйлийг анхаарах нь зүйтэй. Үүнд: 1. Юуны өмнө хүрсэн түвшнээсээ ухарсан, хийж чаддаг байсан зүйлээ чадахгүй болсон дутагдлыг бүх шатанд арилгах хэрэгтэй. Хилийн цэрэг 1989 оны эцсийн байдлаар зуун мянга хол давсан толгой малтай, хэрэгцээт махныхаа бараг 60 хувь, төмсний 42 хувь, хүнсний ногооны 30 орчим хувийг өөрөө хангадаг, нэг хилчинд 3 уналга ноогддог байлаа.

Гэтэл энэ тоо одоо бараг 3 дахин буурсан үзүүлэлт гарсан байна. Эдийн засгийн хямралд гүн орсон өнөөгийн нөхцөлд юуны өмнө хүний амин чухал хэрэгцээ болсон хүнсний хангалтыг сайжруулахад мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх зайлшгүй шаардлага урган гарч байна. Хилийн цэргийн хэмжээнд мал аж ахуй газар тариалангийн үйлдвэрлэлийг ядахнаа 1989 оны түвшинд хүргэж чадвал жил тутам нэг тэрбум гаруй төгрөгийг шинэ техник технологи нэвтрүүлэхэд зарцуулах боломж олж авах юм.

Өнөөдөр хилийн цэргийн хэмжээгээр зуун эхээс бойжуулсан төл улсын дунджаас 10-36 толгойгоор доогуур байна. Жилд зүй бусаар хорогдсон малын тоо улсын дунджаас 3-6 %-иар их байна. Бойжуулсан төл зүй бусаар хорогдсон малын зөрүүгээр тооцвол жил тутам богийн толгойд шилжүүлснээр бараг 12000 толгой мал алдаж байна гэсэн үг юм.

2. Ар талын хангалт үйлчилгээний шинэ эх булаг ашиглагдаагүй нөөцийг олж илрүүлснээр хангалтын сувгийг уртсгах зайлшгүй шаардлагатай байна. Ингэснээр төсвийн хүрэлцээгүй байдлаас гарах

зарим бололцоо бүрдэнэ. Тухайлбал: Улс даяар нэгэнт үгүй болсон ахуйн үйлчилгээг хилийн хороодод өргөжүүлэн зохион байгуулж хил орчмын ард иргэдэд үйлчилгээг хүргэснээр хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж болно. Ялангуяа эрчим хүний төвлөрсөн системд холбогдсон Баян-Өлгий, Увс, Ховд, Хөвсгөл, Өмнөговь, Улаан-Уул, Замын-Үүд, Дорнодын хилийн хороодод энэ боломж илүү бий.

3. Ар талын хангалт үйлчилгээнд хилийн худалдааны боломжийг өргөн ашиглах шаардлагын үүднээс цэргийн худалдааны нэгжийг ХЦУГ-т бий болгох хэрэгтэй гэж бодож байна. Үүний дараа хилийн төлөөлөгчийн газруудыг түшиглүүлэн хангалт-худалдааны баазыг байгуулан ажиллавал ялангуяа тээвэр шатахууны өртөг, зардал ихээхэн хэмнэгдэх болно.

4. Ар талын хангалт үйлчилгээний төлөвлөлтийг бүх шатанд шинжлэх ухааны үндэслэлтэй эдийн засгийн тооцоонд тулгуурлан хийж хэвших. Ингэснээр доод шатны байгууллага нь хийсвэрээр өсгөн төлөвлөж дээд шатны байгууллага нь заавал хасч танаж байдаг хэвшмэл загвар, сэтгэлгээнээс салах шаардлагатай болж байна.

Төлөвлөлтийн үндсэн шаардлага болсон бодит хэрэгцээ, байгаа нөөцийн зөрүүд лимит тогтоон хэрэгжүүлдэг эдийн засгийн бодит хууль зах зээлийн эдийн засгийн үед ч гэсэн нэгэн адил үйлчилдгийг санах хэрэгтэй.

5. Аль ч шатанд захиргааны хүнд суртлыг албадан бий болгож байгаа нягтлан бодох бүртгэлийн давхар бичилтийн системийг олон улсын бүртгэлийн системтэй уялдуулан халах цаг болжээ. Өнөөгийн мөрдөж байгаа давхар бичилтийн системээр ганц кг будаг авахын тулд 6-8 цохолт дамжин хийлгэж цаг алдах явдал их байна. Давхар бичилтийн системийг халахад хяналт шалгалт, ажилтны үнэнч хөдөлмөр чухлаар шаардагдах нь дамжиггүй.

*

*

*